



# “МОН-ГЕО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2025 оны 3-р сарын 17 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай

МУ ын” Компаний тухай хууль”-ийн 59,4 дүгээр зүйл, “Мон-Гео” ХК-ийн дүрмийн 6,2 дахь заалт ,ТУЗ-ийн 2025 оны 3 дугаар сарын 17ны өдрийн ээлжит хурлын шийдэрийг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

Нэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4 дүгээр сарын 27 ны өдрийн 10 цагт өөрийн байранд хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.

Хоёр.Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлаар дараахи асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

А. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн эцсийн тайлангийн талаар ТУЗ-ийн хурлын шийдвэрийг хэлэлцэх,

Б. Компанийн 2024 оны жилийн санхүүгийн тайланд өгсөн “Шинэ Их тэрбум” аудитын байгууллагын дүгнэлтийг сонсох, хэлэлцэх,

В. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулагдах сонгон шалгаруулалтын ажиллагаанд оролцох ,шаардагдах төсөв, төлөвлөгөөг тооцож тухай бүрт нь ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлэх ,

Г. ТУЗ-ийн нэг гишүүнийг нөхөн сонгох,

Д. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх,санхүүгийн тогтвортой байдлыг хангах , өргөжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх , бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор их хэмжээний зээл авах, гэрээ хэлцэл байгуулахыг ТУЗ-ийн хурлын шийдвэрт үндэслэн гүйцэтгэх захиралд зөвшөөрөх,

Е. Тус компанийн эзэмшлийн ХУД-ын 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлал бүхий 8.08 га газар дээр үйлдвэрлэлийн болон бусад зорилгоор ашиглах төслийг шинээр боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг гүйцэтгэх удирдлагад даалгах,

Ё. Компанийн санхүү эдийн засгийн чадамжийг өргөжүүлэх зорилгоор салбар харгалзахгүйгээр бизнес төлөвлөгөө боловсруулан баталж,шат дараалан хугацаатай, хяналттайгаар хэрэгжүүлэх,

Ж. Гүйцэтгэх удирдлагыг өөрчлөх,

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга..... / Х.Анар /

Комиссын нарийн бичгийн дарга..... / М.Алтанцэцэг /

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар ТУЗ-ийн дарга Н.Соёмбыг томил сугай.

Тав. Хурлын тооллогын комиссыг дараахи бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Тооллогын комиссийн дарга : / Н.Бат-Өлзий /

Гишүүд: / Б.Түмэнжаргал /

/ Г.Даваажаргал /

Зургаа. 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай мэдэгдэх өдрийг 2025 оны 3 дугаар сарын 22 ны өдөр , 2025 оны 4 дүгээр сарын 6 ны өдөр байхаар тогтоосугай.

Долоо. Нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 4 дүгээр сарын 6 ны өдөр байхаар шийдвэрлэсүгэй.

Найм. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах зохион байгуулалтын ажиллагаанд "Компанийн тухай хуулийн 59.8, 59.9 дэхь заалтуудыг хэрэгжүүлж ажиллахыг комиссын дарга /Х.Анар/ -д үүрэг болгосугай

ТУЗ-ийн дарга ..... / Н.Соёмбо /

